



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 450

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 58,408,055.43 (тавин найман сая дөрвөн зуун найман мянга тавин таван төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,157,799.08 (нэг сая нэг зуун тавин долоон мянга долоон зуун ерэн есөн төгрөг найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасаж, буулгахыг зөвшөөрсүгэй.

2. Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Албан конторын барилгыг буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын албан конторын зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000862



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 450
дугаар тогтоолын хавсралт

Сэлэнгэ аймгийн ттаварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Конторын барилга	2000	ш	1	58,408,055.43	58,408,055.43	1,157,799.08	57,250,256.35
Нийт						58,408,055.43	1,157,799.08	57,250,256.35
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН						58,408,055.43 (тавин найман сая дөрвөн зуун найман мянга тавин таван төгрөг дөчин гурван мөнгө)	1,157,799.08 (нэг сая нэг зуун тавин долоон мянга долоон зуун ерөн есөн төгрөг найман мөнгө)	57,250,256.35 (тавин долоон сая хоёр зуун тавин мянга хоёр зуун тавин зургаан төгрөг гучин таван мөнгө)